

# Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчид зориулсан сургалт



---

Авлигатай тэмцэх газар  
Хяналт шалгалт, дүн  
шинжилгээний хэлтэс  
2008 он

**[/www.iaac.mn/](http://www.iaac.mn/)**



# Авлигын эсрэг хууль

---

- 2006 оны 07 сард шинэчлэгдэн батлагдсан.
- Хуулийг 2006 оны 11 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлсэн.
- ХОМ гаргаж хугацаа өнгөрсөн жилийн хувьд 2007 оны 06-р сарын 15. Цаашид жил бүрийн 2-р сарын 15-ны дотор.
- ХОМ-той холбоотой тайлан мэдээг дээрх хугацаанаас хойш 14 хоногийн дотор



# ХОМ гаргуулан авах үндэслэл, ач холбогдол

---

- Хүн бүр татвар төлдөгтэй адилхан төрийн албан хаагч бүр хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаж хэвших
- Хуулийн үйлчлэлд хамаарагдах этгээд хөрөнгө, орлогоо мэдүүлснээр төрийн албыг шударга, нээлттэй зарчмаар явуулах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой.
- Авлигаас урьдчилэн сэргийлэх гол арга хэрэгслийн нэг нь хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах явдал
- Төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах эрх зүйн үндэслэл нь төрийн албаны тухай хуульд өмчийн байдлын талаар мэдэгдэх 13.1.10 заалт болон авлигын эсрэг хуульд тусгагдсан.



# Авлигатай тэмцэх газар

---

- Авлигатай тэмцэх газрын дарга 2006 оны 12-р сарын 28-нд томилогдсоноор АТГ байгуулагдсан.
- АТГазар үндсэн 4 хэлтэс, 2 албатай.
  1. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс
  2. Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс
  3. Мөрдөн шалгах хэлтэс
  4. Тамгийн хэлтэс
  5. Дотоод хяналт, аюулгүй байдлын алба
  6. Гүйцэтгэх алба



# Хөрөнгө, орлогын мэдүүлэг

---

- Мэдүүлэгч юуг мэдүүлэх үүрэг хуулиар хүлээсэн бэ?
  - Хөрөнгө
  - Орлого

# Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч гэж хэн бэ?

- Төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч
- Төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан
- ОНРТ-ийн ҮЗ-ийн дарга, Ерөнхий захирал
- Төрийн чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа ТББ-ын удирдах албан тушаалтан
- Бүх шатны сонгуульд нэр дэвшигч

# Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хаана гаргаж өгөх вэ?

- Төрийн өндөр албан тушаалтан болон түүний зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтны ХОМ-ийг АТГазарт
- УДШ-ээс бусад бүх шатны шүүхийн шүүгч, ШТГазар, хэлтэс албаны дарга нар, ажлын албаны ТЗ-ны албан хаагчид ШЕЗ-д
- Засгийн газраас томилогддог албан тушаалтнууд ХОМ-ээ ТАЗөвлөлд
- Бусад албан тушаалтны ХОМ-ийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд
- Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч СЕХ-нд, УИХ-ын сонгуульд нэр дэвшигч сонгуулийн тойргийн хороонд, бүх шатны ИТХ-д нэр дэвшигч аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд тус тус гаргаж өгнө.



# ХОМ гаргагчийн үүрэг

---

- Хуульд заасан хугацаанд гаргаж өгөх
- Үнэн зөв мэдүүлэх
- Эх үүсвэрийн талаар тодорхой тайлбар өгөх
- Их хэмжээний өөрчлөлтийн талаар мэдэгдэх
- Батлагдсан маягтын дагуу асуулт болгонд хариулах
- Засваргүй, товч тодорхой бичих

# ХОМ гаргагчид хүлээлгэх хариуцлага

- Мэдүүлэг гаргагч ХОМ-ээ хугацаа хожимдуулж гаргасан эсхүл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах, түтгэлзүүлэх, халах үндэслэл болно.
- Мэдүүлэгч ХОМ-ээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эх үүсвэрийг нь заагаагүй, түүнийг хэрхэн олсон талаар тайлбар өгч чадахгүй бол АТГазар шалгана. Зөрчил илэрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.



## НИЙТЛЭГ АЛДАА, ЗӨРЧИЛҮҮД

---

- Хугацаа хожимдуулж гаргасан
- Хөрөнгө, орлогынхоо эх үүсвэрийг тайлбарлаагүй
- ХОМ-ээ буруу, асуулгын дагуу бөглөөгүй
- Бусад /гарын үсэг зураагүй, орлогоо 1 сараар мэдүүлсэн гэх мэт/



# Хөрөнгө орлогын мэдүүлгийн бүтэц

---

- Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал
- Орлого
- Хөрөнгө, зээл, бэлэг гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэж байгаа.



## АВЛИГЫН ТУХАЙ МЭДЭГДЭХ

---

Дараахь албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаархи мэдээллийг нэн даруй Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй:

- шүүгч;
- прокурор;
- цагдаа, тагнуулын байгууллагын албан тушаалтан;
- төрийн аудитын болон мэргэжлийн хяналтын байгууллагын албан тушаалтан;
- төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан.



# Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хадгалах, ашиглах, мэдээлэл өгөх тухай

---

- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нууцын болон гэнэтийн аюулаас /гал,ус гэх мэт/ хамгаалах шаардлагыг хангасан төмөр шүүгээнд хадгална.
- Байгууллагын салбар, бие даасан нэгж тус бүрээр хөрөнгө, орлогын мэдүүлгийг ангилж, мэдүүлэг гаргагч тус бүрт хөрөнгө, орлогын мэдүүлгийг хадгалах хавтас, дугтуй нээж, жил бүрийн мэдүүлэг, түүний өөрчлөлтийн тухай болон бусад холбогдох баримтыг нэмж хадгална.
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хадгалах хугацаа 5 жил байна. Хадгалах хугацаа нь дууссан мэдүүлгийг мэдүүлэг гаргагчид өөрт нь, хэрэв нас барсан бол эхнэр буюу нөхөр, эсхүл хууль ёсны өв залгамжлагчид нь шилжүүлж өгнө.



# Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хадгалах, ашиглах, мэдээлэл өгөх тухай

---

- Эрх бүхий албан тушаалтан нь Авлигатай тэмцэх газрын дарга, өөрийн байгууллагын удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө, орлогын мэдүүлгийг хадгалж байгаа газраас гаргах, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад дамжуулах, үзүүлэхийг хориглоно.
- Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар дараахь хэлбэрээр мэдээлэл өгнө.
  - Журмын “хавсралт-1” маягтын хуулбараар;
  - Нийтийн болон электрон шуудангаар;
  - Амаар;
  - Холбооны хэрэгслээр;
  - Хууль, тогтоомжоор хориглоогүй бусад хэлбэр.
- Иргэд, олон нийт албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээлэлтэй танилцахын тулд:
  - “Иргэд олон нийтэд мэдээлэх, мэдээлэл өгөх журам” –тай танилцана.
  - Журмын хавсралт болох мэдээлэл хүсэх хүсэлтийн маягтыг бөглөж ЭБАТ-наар дамжуулан хүсэлтэнд зөвшөөрөх өгөх албан тушаалтанаас зөвшөөрөл авна.